



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 83,002,000.00 (наян гурван сая хоёр мянга) төгрөгийн балансын үнэ бүхий, үлдэх өртөггүй хөрөнгийн цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал, бригадын генерал Д.Батжаргал, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулах Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын азрын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 438 дугаар тогтоолын хавсралтын 2, 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫНАЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Д.Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ



000014



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 02 дугаар сарын 02ний өдрийн
72 дугаар тогтоолын хавсралт

**ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ХИЛ ХАМГАЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ БАЛАНСАД ШИЛЖКҮЛЭХ,
ЦААШИД АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНİЙГ ШИНЭЧЛЭН ТӨГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/Д	Тээврийн хэрэгслийн нэр, марк, улсын дугаар	Ашиглал тад орсон он	Нийт балансын үнэ, хууримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа (жил)
1	УАЗ-326901, улсын дугаар УБӨ 89-87	2005	41,680,000.00	1,000,000	1
2	Газель-32613Н, улсын дугаар УБИ 42-31	2007	41,322,000.00	1,000,000	1
	Нийт дүн		83,002,000.00 (наян гурван сая хоёр мянга)	2,000,000.00 (хоёр сая)	